



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/А25

Булган сум

### Марш тактик-тусгай бэлтгэлийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.1, 1.10, Батлан хамгаалахын сайдтай аймгийн Засаг даргын 2023 онд хамтран ажиллах гэрээний 1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Монгол улсад үндэсний Зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны түүхт 102 жилийн ойг тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 2022 оны 03 дугаар сарын 15-ний өдөр Хилийн цэргийн 0286 дугаар ангийг түшиглэн сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ч.Энхбаяр), Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч (Хурандаа М.Эрдэнэбуян)-т хариуцуулсугай.

3. Тэмцээний шагналын зардал 5,540,000 (таван сая таван зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
03 дугаар сарын 06-ны өдрийн А/03 дугаар  
захирамжийн хавсралт



### ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ

Д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Бүгд
1	“Марш тактик-тусгай бэлтгэл”-ийн аварга шалгаруулах тэмцээний зардал	3.360.000	1-р байр 1.000.000 2-р байр 800.000 3-р байр 600.000 Өргөмжлөл 3*60000=180.000 Батламж 3*40000=120.000 Медаль 33*20.000=660.000
2	Буудлагын тэмцээний медаль	180.000	Буудлагын тэмцээний медаль 9*20.0000=180.000
3	Хоолны зардал	2.000.000	90 албан хаагч
БҮГД			5.540.000